



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 1/97

Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран  
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд  
шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 5 дугаар сарын 1-ээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 3 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 780, 136, Засаг даргын 2008 оны 133 дүгээр захирамжийн хавсралтын 38 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200396

Аймагын Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 14-ны  
 тогтоолын 4 дүгээр захирамжийн хэвсрэлт

№	Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн				Газар өмчлөх эрх шилжүүлсэн		Газрын байршил	Газрын хэмжээ /м2/	Газрын үнэ
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистр	Овог нэр	Регистр			
1	Шархүү	Түвд	Түвшин	ЗИ69080914	Т.Санжаажамц	ЗЮ92012414	Боржигон 17-5	659	2108800
					Т.Санжаадорж	ЗЮ94110814			
					Б.Мянганцоо	ЗЮ69122960			
2	Боржигон	Мишиг	Жаргалсайхан	ЗК57091111	М.Оюунцэцэг	ЗК60041200	Арижих 17-22	1200	3840000
					Ж.Батбилэг	ЗК91102416			
					Ж.Цамба	ЗК04230413			
3	Цэнгэл	Дашдаваа	Байгальмаа	ЗЮ69100901	Б.Чалнаадорж	ИМ90031712	Мандал 6-5	836	2675200
					Б.Лхамсүрэн	ЗЮ94052408			
					Т.Болд	ИМ67010532			